

АНГИ, БҮЛЭГ:

ШИФР:

11 ДҮГЭЭР АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

“А” ХУВИЛБАР


ХУГАЦАА: 80 мин

Нэг. СОНГОХ

1. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой.
..... гэдэг нь баялаг, нэр хүнд, эрх мэдлийн хувьд ялгаатай, тодорхой хэв шинжит харилцаа бүхий нийгмийн нийтлэг.
А.Нийгмийн давхраажилт В.Нийгмийн давхраа С.Нийгмийн ялгарал D.Нийгмийн нийтлэг
2. Соёлын орон зай гэж юу вэ?
А.Соёлын үнэлэмжүүдийн харилцан нөлөөллөөр бий болж байдаг оюун санааны орчин
В.Соёлын харилцаа бүх талаар өргөжин тэлэх үйл явц
С.Янз бүрийн ард түмний эрх чөлөөний талаарх мэдрэмж
D.Өөр соёлын орчинд орох үед бий болж байдаг оюун санааны орчин
3. Хэрэглэгчдийн эцсийн хэрэглээндээ зориулан худалдан авахад зарцуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлын нийлбэр дүнгээр ДНБ-ийг тодорхойлох аргыг юу гэж нэрлэдэг вэ?
А. ДНБ-ийг орлогоор тооцох В. ДНБ-ийг өнөөгийн үнээр тооцох
С. ДНБ-ийг тогтмол үнээр тооцох D. ДНБ-ийг зардлаар тооцох
4. “Иргэний нийгэм нь төрөөс үл хамаарах өөр хоорондын харилцаа, эрх зүйгээр зохицуулагддаг хувь хүмүүс, анги бүлэг, институтуудын нийлбэр цогц” юм. Иргэний нийгмийн тухай тодорхойлсон сэтгэгчдээс хэний үзэл санаа хэлсэн үг вэ?
А.К.Поппер В. Р.Путнам С. Р. Дарендорьф D. Г. Гегель
5. “Хүмүүс байгалиас заяасан эрх чөлөөтэй. Гэтэл яагаад төр засагт захируулж, эрх чөлөөгөө хязгаарлуулдаг юм бэ?” гэсэн асуултыг тавьж түүнд тодорхой хариултыг гаргаж үзэл бодлоо илэрхийлсэн сэтгэгч хэн бэ?
А. Ж. Руссо В. Т.Гоббс С. Л.Актон D. Ж. Локк
6. Засаг төрийн эрх мэдлийг хуваарилах, хүний эрхийг баталгаажуулах, эрх зүйт төрийн үндсийг бэхжүүлэх зэрэг нь аль ёсны үзэл баримтлалд хамаарах вэ?
А. Төрийн албаны эрх зүйд захирагдах ёс В. Иргэний эрх зүйд захирагдах ёс
С. Эрх зүйд захирагдах ёс D. Үндсэн хуульт ёс
7. Цэгийн оронд тохирох оныг сонгоорой. Монгол улс бүрэн эрхт улсын хувьд олон улсын эрх зүйн хүрээнд Де-факто улс байх статусыгон хүртэл эдэлж байсан.
А. 1990 он В. 1945 он С. 1948 он D. 1961 он
8. Олон улсын харилцааны үндсэн оролцогч аль нь вэ?
А.Олон улсын байгууллага В.Бүрэн эрхт, тусгаар тогтносон улс
С.Үндэстэн дамнасан корпораци D.Олон улсын төрийн бус байгууллага
9. К. Марксын үзсэнээр капиталистууд ажилчин ангийг хэрхэн мөлждөг вэ?
А. Өөрийн ажилчдын цалинг өгөлгүйгээр В.Нэмүү өртгийг ажилчдаар бүтээлгэн өөрсдөө авч
С. Ажилчдын шалтгаангүйгээр ажиллуулан D. Ашгийг ажилчдад хуваарилж
10. Соёлын үйлдвэрлэлд оюуны өмч, зохиогчийн эрхтэй холбоотой бүтээл, туурвил, үйлчилгээ багтана. Үүнд хамаарах ойлголт аль нь вэ?
А.Угсаатны зан үйл В.Соёлын эрх чөлөө С.Соёлын адилсал D.Соёлын орон зай
11. Нийгэм, эдийн засгийн үзэгдэлд өсөлтийн хурдыг хувиар тооцоолоход үзүүлэлт нь 100-аас дээш утгатай бол ямар утгыг харуулах вэ?
А.Өсөлт, бууралт байхгүй В.2 дахин хурдтай өссөн
С.Буурсан утгыг илэрхийлнэ D.Өссөн утгыг илэрхийлнэ
12. Дараах өгөгдлүүдийн аль нь мөнгө зээлийн бодлогын нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгод хамаарах вэ?
А. Хувь хүн болон ААН-ээс авах татварын хэмжээг бууруулах

- В. Төрийн өөрийн хөрөнгөөр нийтийн шинжтэй ажил зохиох
 С. Засгийн газрын хөтөлбөр, төсөл боловсруулж зардлаа ихэсгэх
 D. Зээлийн хүүг бууруулж, гүйлгээнд байгаа мөнгийг өсгөх
13. Нийгэмд онцгой үүрэгтэй дөрөв дэх засаглал аль нь вэ?
 А. Улсын их хурал В. Засгийн газар С. Хэвлэл мэдээлэл D. Шүүх
14. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/
 нь ардчилсан нийгэм бүх иргэдэд адил тэнцүү боломж олгодог. Энэ нь хэн нэгнийг илүү харж, эрх дарх олгохгүй гэсэн үг юм.
 А. Хууль дээдлэх зарчим В. Шударга байх зарчим С. Нээлттэй зарчим
 D. Зөвшилцлийн зарчим
15. Дараах тохиолдлуудаас алинд нь өмчлөх эрх үүсэхгүй вэ?
 А. Хөдлөх эд хөрөнгийг өөрийн эзэмшилд шилжүүлж авсан үеэс
 В. Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ авснаар
 С. Гээгдэл эд зүйл олж авснаар
 D. Ном худалдаж авбал номыг өөрийн мэдэлд оруулсан үеэс
16. Гэмт хэргийн талаар мэдсэн хэрнээ цагдаагийн байгууллагад мэдээлэл өгөхгүй байх нь юм.
 А. Эс үйлдлээр эрх зүйн зөрчил гаргасан гэмт хэргийн үйлдэл
 В. Хууль зөрчсөн гэм буруутай үйлдэл
 С. Хуульд заасан гэм буруутай үйлдэл
 D. Хуульд заасан үүргийг гүйцэтгэхгүй байхыг эс үйлдэл гэнэ
17. Олон улсын харилцааны хатуу хүчний бодлогын үйлдлийн төрлийг сонгоно уу.
 А. Захирах чадвар В. Урамшуулал С. Үнэмшил D. Сэтгэл татах чадвар
18. Манай улстай иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаатай улс аль нь вэ?
 А. БНХАУ В. ОХУ С. АНУ D. БНСУ
19. Зуднаар малаа алдсан малчид амьжиргаагаа залгуулах, ашигтай болох үүднээс суурин газар луу шилжин амьдрах болсон нь Улаанбаатар хотын хүн ам эрс ихсэж, агаарын бохирдол нэмэгдэхэд хүргэсэн. Нийгмийн өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлийн алинд нь хамаарах жишээ вэ?
 А. Соёлын технологи В. Нийгмийн дэвшил С. Нийгмийн шинэчлэл D. Нийгмийн шинэтгэл
20. Орчин үеийн буюу аж үйлдвэржсэн нийгмийн үндсэн шалгуурт хамааралгүй шинжийг олно уу?
 А. Аж үйлдвэр эдийн засгийн гол талбар байна.
 В. Шинжлэх ухааны итгэл үнэмшлийн тогтолцоо тэргүүлэх үүрэгтэй
 С. Хувийн хүсэл зоргийг гэхээсээ нийгэм-хамт олны зарчимд нийцүүлэн хувь хүн амьдардаг
 D. Орчин үеийн төрийн бүтэцтэй буюу үндэсний төрийн бүгд найрамдах засаглал бүхий төртэй байна.
21. “Телевизийн олон суваг олон нийтийн ухамсарт таалагдаж, тэднийг байлдан дагуулахын тулд америкчлал, европчлол, өрнөдийн элдэв уриа лоозон дэвшүүлэн, халамжлагч ивээгчийн дүрээр халхавчлан зүсэн зүйлээр довтолж байна” гэсэн монгол судлаачийн дүгнэлт нь дараах ойлголтоос алийг түлхүү илэрхийлж байна вэ?
 А. Соёлын дархлаа сулрах шалтгаан В. Соёлоо хадгалж үлдэх шалтгаан
 С. Соёлоо эрхэмлэхийн шалтгаан D. Соёлын суурь зарчмын шалтгаан
22. “...Манай малчид уламжлалт эд өлгийн зүйлс хэрэглэхээ больж байна. Жишээ нь айргаа хөхүүрэндээ эсгэхээ больж хятадын цэнхэр саванд эсгэдэг боллоо. Гэрийн бүслүүрээ малынхаа үс хялгасаар биш, хятадын дээсээр хийдэг боллоо, морио унахаа больж мотоцикл хэрэглэдэг боллоо...” Энэхүү эх сурвалжид соёлын ямар ойлголтыг хөндөж байна вэ?
 А. Соёлын дархлаа алдагдах В. Соёлын адилсал идэвхжих
 С. Соёлын эрх чөлөө хязгаарлагдах D. Соёлын цочирдолд орох
23. 2023 онд Монгол улсын экспорт нь 490 тэрбум төгрөг, импорт нь 330 тэрбум төгрөг байсан бол тус оны МУ-ын гадаад худалдааны тэнцлийг тооцоолно уу.
 А. 820 В. -160 С. 160 D. - 820
24. Хэрэв засгийн газар эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор зээлийн хүүгийн хэмжээг бууруулах гэж байгаа бол аль аргыг ашиглах вэ?

- A.Бонд гаргаж худалдана B.Бондыг эргүүлэн худалдаж авна
 C.Хувьцаа гаргаж худалдана D.Хувьцаагаа эргүүлэн худалдаж авна
25. 2016 онд УИХ-ын сонгуульд МАН нийт сонгогчдын 46 хувийн санал авсан ч парламентийн суудлын 85 хувь буюу 65 суудал авсан бол бусад нам эвслүүд нийт сонгогчдын 54 хувийн санал авсан хэдий ч парламентад 11 суудал авч байжээ. 2016 оны УИХ-ын сонгууль сонгуулийн ямар тогтолцооны онцлогийг харуулсан байна вэ?
 A.Можаритори тогтолцоо B.Пропорциональ тогтолцоо
 C.Хувь тэнцүүлэх тогтолцоо D.Холимог тогтолцоо
26. Чиний бодлоор дараах ойлголт нь ардчиллын ямар үнэт зүйлийг зөрчсөн байна вэ?
Ардчилсан нийгэмд хаан, ерөнхийлөгч, сайд нар л хуулиас дээгүүр эрх мэдэлтэй, харин ард иргэд нь хуулийг сахиж, түүнийг зөрчвөл хариуцлага хүлээнэ
 A. Нийтэд тайлагнах, ил тод байх ёс B. Иргэдийн улс төрийн оролцоо
 C. Олон намын тогтолцоо D. Хуулийн засаглал
27. Туслах малчин Цэлмэг үхэр хариулж явахад аянга буусны улмаас хоёр үхэр үхсэн бол эрсдлийг хэн хариуцах вэ?
 A.Туслах малчин Цэлмэг үхрийн үнийг өмчлөгчид төлнө.
 B.Гэнэтийн осол, давтагдашгүй хүчний улмаас үхэр үхсэн тул өмчлөгч өөрөө энэ эрсдлийг хүлээнэ
 C.Малчин Цэлмэгийн буруу биш учраас эрсдлийг хариуцахгүй
 D. Гэнэтийн осол, давтагдашгүй хүчний улмаас болсон ч гэсэн хариуцсан ажил тул туслах малчин Цэлмэг өмчлөгчийн хохирлыг барагдуулна.
28. Захиргааны байгууллагын хууль бус шийдвэрийн улмаас эрх нь зөрчигдсэн иргэн хуулийн этгээд нь дээд шатны захиргааны байгууллагын гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл захиргааны хэргийн шүүхэд хэд хоногийн дотор нэхэмжлэл гаргах вэ?
 A.7 хоног B.14 хоног C.30 хоног D.45 хоног
29. Олон улсын харилцааны улс оролцогчдыг дотор нь их гүрэн, дунд улс, бага улс хэмээн ангилдаг. Их гүрнийг илэрхийлсэн тодорхойлолтыг сонгоорой.
 A. Олон улсын харилцаанд нөлөө багатай ч дэлхий улсуудын 2/3 нь энэ ангилалд багтдаг
 B. Өөрийн ойрын хүрээлэлдээ ялангуяа хөрш улсууд, бүс нутагтаа баттай нөлөөлдөг.
 C. Бүс нутагтаа нөлөөтэй, голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсууд байдаг.
 D. Өөрийн болон хөрш, холбоотон, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах чадалтай байдаг.
30. Монгол улстай түншлэлийн харилцаатай улсуудыг харуулсан бүдүүвчийг гүйцээгээрэй.



- A. а-Стратегийн түншлэл, b-Энэтхэг B. а-Иж бүрэн стратегийн түншлэл, b-БНХАУ
 C. а-Стратегийн түншлэл, b-БНСУ D. а-Иж бүрэн түншлэл, b-АНУ

Хоёр. ХАРГАЛЗУУЛАХ

31. Социализмийн үеийн Монголын нийгмийн давхраажилтын ангиллыг бүтэцтэй нь тохируулна уу?

A	Малчдын	1	Аж үйлдвэрийн тээврийн барилгын, үйлчилгээний,хөдөө аж ахуйн салбартай
B	Ажилчдын	2	Босоо шатлалын дагуу эрх мэдэл, орлогын ялгаатай
C	Сэхээтний	3	Оюуны хөдөлмөрийн түвшнээр нь сэхээтэн ба албан хаагчид
D	Номенклатура	4	Ядуучуудын давхрааг бүрдүүлж байв

A- B- C- D-

32. Зөв харгалзуулаарай.

A	Соёлын адилсал	1	Хүмүүс эх хэлээрээ ярьж, хувь чанараа хөгжүүлэх, өөрийн соёлыг бүтээн туурвих бололцоог эдлэх эрх
B	Соёлын эрх чөлөө	2	Соёл өөрийн үнэт зүйлсээ хамгаалж, оршин тогтнолоо бэхжүүлэн баталгаажуулах чадвар
C	Соёлын дархлаа	3	Өөрийгөө ойлгох, тэрхүү соёлыг тээгч гэдгээ ухаарах байдал
D	Эрх чөлөө	4	Хүн бүр бусдын эрхийг хүндлэн өөрийн үйлдлээ сонголтын үндсэн дээр хийх боломж

A- B- C- D-

33. ДНБ-ий үзүүлэлтийг тодорхойлолттой нь харгалзуулна уу.

A	Бодит ДНБ	1	Дотоод болон хилийн чанад дахь Монголын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг
B	Нэрлэсэн ДНБ	2	Тухайн жилийн бараа бүтээгдэхүүнийг өнөөгийн үнээр тооцохыг хэлнэ
C	Үндэсний нийт бүтээгдэхүүн	3	Тухайн жилийн бараа бүтээгдэхүүнийг тогтмол үнээр тооцох үзүүлэлт
D	Дотоодын нийт бүтээгдэхүүн	4	Тухайн улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн, эцсийн бараа, үйлчилгээний зах зээлийн үнийн дүн

A- B- C- D-

34. Гадаад худалдааны бодлогын арга механизмийг зөв харгалзуулна уу.

A	Гаалийн татвар	1	Улс орнуудын хооронд бараа, үйлчилгээний шилжих хөдөлгөөн
B	Гаалийн хөнгөлөлт	2	Импортын барааны өрсөлдөх чадварыг сулруулах зорилготой.
C	Гаалийн хязгаарлалт	3	Тодорхой төрлийн барааны импортод квот тогтооно.
D	Олон улсын худалдаа	4	Тухайн улсын техник, технологийн хөгжилд зайлшгүй шаардлагатай бөгөөд үйлдвэрлэлийн зардалд өндөр хувь эзэлдэг бараа.

A- B- C- D-

35.Д. Истоны улс төрийн системийн ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу.

A	Шаардлага	1	Аль нэг нам, нэр дэвшигчийн төлөө санал өгөх, шийдвэрийг дэмжиж буйгаа илэрхийлэх
B	Оролцооны дэмжлэг	2	Улс төрийн системийн дотроос эсвэл, түүнийг хүрээлэн байгаа экологи, эдийн засаг, соёл зэрэг янз бүрийн системүүдээс гарч буй тулгалтууд
C	Бодит дэмжлэг	3	Татвар төлөх, төрийн болон цэргийн алба хаших, хууль дүрмийг дагаж мөрдөх
D	Шийдвэр	4	Төрийн бодлогын тодорхой илрэл болсон төрийн хууль тогтоомж, мэдээлэл, сурталчилгаа гэх мэт

A- B- C- D-

36. Улс төрийн институудуудын чиг үүргийг зөв харгалзуулаарай.

A	Сонирхолын бүлэг	1	УТС-ийн бүрдэл хооронд холбоо тогтоох, мэдээлэл дамжуулах сувгийн үүрэг гүйцэтгэх
B	Улс төрийн нам	2	Сонирхлыг хэрэгжүүлэх
C	Төр	3	Сонирхлыг нэгтгэх
D	Хэвлэл мэдээлэл	4	Сонирхол илэрхийлэх

A- B- C- D-

37. Монгол улсын шүүхийн тогтолцоог зөв харгалзуул.

A	Анхан шатны шүүх	1	Хүний эрхийг ханган ажиллана.
B	Давж заалдах шатны шүүх	2	Улсын дээд шүүх
C	Хяналтын шатны шүүх	3	Сум, сум дундын, дүүргийн шүүх
D	Шүүх	4	Аймаг нийслэлийн шүүх

A- B- C- D-

38. Төрийн хүний эрхийг хамгаалах чиг үүргийг зөв харгалзуулаарай.

A	Хүндэтгэх	1	Хүний эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн баталгааг бий болгох
B	Хангах	2	Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх
C	Хамгаалах	3	Хүн эрхээ эдлэхэд ямарваа нэгэн саад учруулахгүй, зөрчихгүй байх.
D	Ахиц дэвшил гаргах	4	Хүний эрхийн талаар олсон ололт амжилтаа бататгах

A- B- C- D-

39. Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллага, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудыг харгалзуулна уу.

a	UNDP	1	НҮБ-ын “Хөгжлийн хөтөлбөр”
b	UNESCO	2	Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга
c	АСЕАН	3	НҮБ-ын “Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага”
d	АПЕК	4	Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо

A- B- C- D-

40. Олон улсын байгууллагын ангиллыг тохируулаарай.

a	Глобал түвшин	1	Европын холбоо
b	Бүс нутгийн түвшин	2	Нэгдсэн үндэсний байгууллага
c	Олон улс хамтран байгуулсан	3	Соросын сан
d	Хувь хүн байгуулсан	4	Евразийн эдийн засгийн холбоо

A- B- C- D-

АНГИ, БҮЛЭГ:

ШИФР:

11 ДҮГЭЭР АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

“В” ХУВИЛБАР

ХУГАЦАА: 80 мин

Нэг. СОНГОХ

41. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой.
.....гэдэг нь тодорхой хэв шинжит харилцаа бүхий тэгш бус байдлын тогтолцоо.
А.Нийгмийн давхраажилт В.Нийгмийн давхраа С.Нийгмийн ялгарал D.Нийгмийн нийтлэг
42. Соёлын орон зай, кибер орон зай гэсэн ойлголтуудын хамаарлыг аль нь зөв илэрхийлсэн бэ?
А.Энэ хоёр ойлголт ижил утгатай
В.Соёлын орон зайн нэг хэлбэр нь кибер орон зай юм.
С.Кибер орон зайн нэг хэлбэр нь соёлын орон зай юм.
D. Энэ хочр ойлголт хоорондоо ямарч хамаагүй
43. Тухайн улсын хэмжээнд жилийн турш үйлдвэрлэсэн баялгийг орлогын нийлбэр дүнгээр ДНБ-ийг тодорхойлох аргыг юу гэж нэрлэдэг вэ?
А. ДНБ-ийг тогтмол үнээр тооцох В. ДНБ-ийг өнөөгийн үнээр тооцох
С. ДНБ-ийг орлогоор тооцох D. ДНБ-ийг зардлаар тооцох
44. Иргэний нийгэм нь улс төрийн болон нийгмийн харилцааг хөгжүүлэгч, нийгмийн бүлэглэлүүдийн эдийн засаг, нийгэм, улс төрийн үйл ажиллагаанд оролцох оролцоог идэвхжүүлэгч механизм юм.
А.К.Поппер В. Р.Путнам С. Р. Дарендорьф D. Г. Гегель
45. “Нийгмийн гишүүн бүрийн амь бие, эд хөрөнгийг нийтийн хүчээр сахин хамгаалах чадвартай нийгмийн холбооны хэлбэрийг олох хэрэгтэй бөгөөд гишүүн бүр энэ нэгдэлд нэгдэх ёстой” гэх үзлээрээ хүний эрх, эрх чөлөөг төрийн хүчнээс хамгаалах тухай илэрхийлсэн сэтгэгч хэн бэ?
А. Ж.Локк В. Т.Гоббс С. Л.Актон D. Ж. Руссо
46. Шударга, энэрэнгүй, хүнлэг, тэгш, бусдын эрх ашгийг зөрчихгүй байх нь аль ёсны үзэл баримтлалд хамаарах вэ?
А. Үндсэн хуульт ёс В. Иргэний эрх зүйд захирагдах ёс
С. Эрх зүйд захирагдах ёс D. Захиргааны эрх зүйд захирагдах ёс
47. Цэгийн оронд тохирох оныг сонгоорой. Монгол улс бүрэн эрхт улсын хувьд олон улсын эрх зүйн хүрээндоноос Де-юре улс байх статустай болсон.
А. 1961 он В. 1945 он С. 1948 он D.1990 он
48. Засгийн газрын оролцоо, дэмжлэггүйгээр улс, үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг глобал түвшний оролцогчдыг юу гэж нэрлэдэг вэ?
А.Улс В.Улс оролцогч С.Улс бус оролцогч D.Олон улсын байгууллага
49. Давхраажилтын талаарх К. Марксын үзэл санаанд үл хамаарах нь аль вэ?
А. Ангийн ялгаа нь ашиг сонирхлын ялгаад хүргэдэг
В. Ангийн зөрчил нь нийгмийн өөрчлөлтийн хөдөлгөгч хүч болдог
С. Нийгмийн зөрчил нь зөвхөн ангийн ялгаанаас гадна шашин, үзэл суртал, итгэл үнэмшил зэргээс ч хамаарна.
D. Капитализм дахь цөөнх баяжиж, олонх ядуурсан төлөв нь ангийн зөрчлийг хурдатгаснаар тэгш байдлыг тогтоох өргөн олны хувьсгалт тэмцлийн түүхэн нөхцөл бүрдэнэ.
50. Соёлын үйлдвэрлэлд оюуны өмч, зохиогчийн эрхтэй холбоотой бүтээл, туурвил, үйлчилгээ багтана. Үүнд хамаарах ойлголт аль нь вэ?
А.Компьютерийн тоглоом В.Соёлын эрх чөлөө С.Соёлын даяаршил D.Соёлын орон зай
51. Нийгэм, эдийн засгийн үзэгдэлд өсөлтийн хурдыг хувиар тооцоолоход үзүүлэлт нь 100-аасбага утгатай бол ямар утгыг харуулах вэ?
А. Өсөлт, бууралт байхгүй В. 2 дахин хурдтай буурсан
С. Өссөн утгыг илэрхийлнэ D. Буурсан утгыг илэрхийлнэ
52. Дараах өгөгдлүүдийн аль нь төсвийн бодлогын нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгодхамаарах вэ?
А. Зээлийн хүүг бууруулж, гүйлгээнд байгаа мөнгийг өсгөх

- В. Засгийн газар бонд гаргаж худалдах, худалдан авах
 С. Зээлийн хүүг өсгөж, гүйлгээнд байгаа мөнгийг бууруулах
 D. Хувь хүн болон ААН-ээс авах татварын хэмжээг бууруулах
53. Нийгэмд олон түмэнд үйлчилж, эрх мэдлийг хянах үүрэгтэй, нийгмийн “хоточ нохой” гэж нэрлэгддэг субъект аль нь вэ?
 А.Засаг дарга В.Шүүгчид С.Ерөнхийлөгч D.Сэтгүүлчид
54. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. Улс төрийн намууд, нийгмийн бүлгүүдийн хооронд үзэл бодол, байр суурийн ялгааг нэгтгэх арга зам нь юм.
 А. Шударга байх зарчим В. Хууль дээдлэх зарчим С. Нээлттэй зарчим
 D. Зөвшилцлийн зарчим
55. Өмчлөх эрх гэдэг нь эдийн болон эдийн бус баялагийг ашиглах, эзэмших, захиран зарцуулах боломжийг хэлнэ. Тэгвэл дараах ойлголтуудаас эдийн бус баялагт үл хамаарахыг нв олно уу.
 А.Оюуны өмч, зохиогчийн эрх В.Ажил хэргийн нэр хүнд
 С.Газар өмчлөлийн гэрчилгээ D.Нэр төр, алдар хүнд
56. Олон нийтийн газар бие зассан, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн этгээдэд ямар төрлийн шийтгэл оногдуулах вэ?
 А.Торгох В.Тусгайлан олгосон эрхийг хасах С.Баривчлах D.Түр саатуулах
57. Олон улсын харилцааны зөөлөн хүчний бодлогын үйлдлийн төрлийг сонгоно уу.
 А.Захирах чадвар В.Эдийн засгийн хүч С.Цэргийн хүч D.Сэтгэл татах чадвар
58. Манай улстай стратегийн түншлэлийн харилцаатай улс аль нь вэ?
 А.БНХАУ В. ОХУ С. АНУ D. БНСУ
59. Ихэнх хосууд хуримлахдаа монгол зан үйлээ дагаж байгаа ч өрнөдийн гэрлэх зан үйл аль хэдийн нэвтэрч гэрлэх ёслолыг өөрчилж байгаа нь дараах ойлголтуудын алинд нь хамаарах вэ?
 А.Нийгмийн хувьсгал В.Нийгмийн дэвшил С.Нийгмийн шинэчлэл D.Нийгмийн шинэтгэл
60. Уламжлалт буюу аж үйлдвэржилтээс өмнөх нийгмийн үндсэн шалгуурт хамааралгүй шинжийг олно уу?
 А. Газар тариалангийн аж ахуй болон түүнээс өмнөх хэлбэрийн аж ахуйтай
 В. Шашин эсвэл домгийн итгэл үнэмшлийн тогтолцоотой
 С. Хүний амьдралын үйл ажиллагааны гол талбар нь өрх гэр бүлийн хүрээ байна.
 D. Нийгмийн хамт олны зарчимд нийцүүлэх гэхээсээ хувийн хүсэл зоригийг хэрэгжүүлэхийг эрхэмлэдэг.
61. “Хүнийг өдөр бүр телевизийн дэлгэц болон дэлхийн цахим сүлжээний шүүлтүүр муутай мэдээллээр угжаад байвал хүний, түүний эргэн тойрныхны мэдлэг туршлага, үнэт зүйл алдагдах нь илэрхий” гэсэн мэдээлэл нь дараах ойлголтоос алийг түлхүү илэрхийлж байна вэ?
 А. Соёлын дархлаа сулрах шалтгаан В. Соёлоо хадгалж үлдэх шалтгаан
 С. Соёлоо эрхэмлэхийн шалтгаан D. Соёлын суурь зарчмын шалтгаан
62. Өргөн уудам нутагт тархан суух нүүдэлчид эргэх дөрвөн улиралд зөвхөн байгальтайгаа харилцаж, дураараа амьдардаг байсан нь тэдний аливаа дэг журамд орох дургүй, өөрийгөө хүндэтгэдэг, биеэ тоосон цагийн мэдрэмж муутай зан төрхийг бүрдүүлжээ. Байгалийн эрс тэс уур амьсгалд янз бүрийн нөхцөлтэй газраар байнга сэлгэн амьдардаг нь нүүдэлчдийг ямар ч шинэ нөхцөлд амархан дасан зохицдог зан байдалд сургажээ. Энэхүү эргэцүүлэл нь доорх өгөгдлүүдийн алинд хамаарах вэ?
 А.Соёлын эрх чөлөөний суурь зарчим В. Соёлын даяаршил
 С. Соёлын эрх чөлөө D.Соёлын үйлдвэрлэл
63. 2023 онд Монгол улсын экспорт нь 490 тэрбум төгрөг, импорт нь 330 тэрбум төгрөг байсанбол тус оны МУ-ын гадаад худалдааны нийт эргэлтийг тооцоолно уу.
 А. 820 В. -160 С. 160 D. - 820
64. Хэрэв засгийн газар эдийн засгийн уналт, инфляцитай тэмцэж байгаа бол аль аргыг ашиглах вэ?
 А.Бонд гаргаж худалдана В.Бондыг эргүүлэн худалдаж авна
 С.Хувьцаа гаргаж худалдана D.Хувьцаагаа эргүүлэн худалдаж авна

ХОЁР. ХАРГАЛЗУУЛАХ

71. Манжийн эрхшээлийн үеийн Монголын нийгмийн давхраажилтын хамаарах бүтэцтэй нь тохируулна уу?

A	Нийт Монгол хошуудын засаг ноёд нь	1	Өмч хөрөнгө эрх мэдэлгүй гэрийн боолууд
B	Дээд давхраа	2	Засаг ноёдоос хамгийн олон нь алтан ургийн ноёд байсан
C	Дунд давхраа	3	Уг гарвалаараа 5 янз байдаг
D	Доод давхраа	4	Ноёдод татвар нийлүүлж, мал сүргийг нь адгуулах үүрэгтэй

A- B- C- D-

72. Зөв харгалзуулаарай.

A	Соёлын орон зай	1	Өөр соёлын орчинтой биечлэн танилцах аялал
B	Соёлын даяаршил	2	Оюуны өмч, зохиогчийн эрхтэй холбоотой бүтээл, туурвил, үйлчилгээ.
C	Соёлын үйлдвэрлэл	3	Тусгаар соёлууд дэлхийн нэгдмэл соёлд нэгдэн нийлэх үйл явц
D	Соёлын аялал жуулчлал	4	Улс үндэстэн хүмүүсийн хамтын мэдрэмж

A- B- C- D-

73. ДНБ-ний үзүүлэлтийг тодорхойлолттой нь харгалзуулна уу.

A	ДНБ-ийг орлогоор тооцох	1	Тухайн улсын хэмжээнд жилийн турш үйлдвэрлэсэн баялгийн орлогын нийлбэр дүн
B	Нэг хүнд ногдох ДНБ-ийн өсөлт	2	Хэрэглэгчдийн эцсийн хэрэглээндээ зориулан худалдан авахад зарцуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлбэр дүн
C	Бодит ДНБ-ийн өсөлт	3	Тухайн улсын улсын эдийн засгийн чадавхыг харуулдаг.
D	ДНБ-ийг зардлаар тооцох	4	Тухайн улсын иргэдийн амжиргааны түвшинг илтгэнэ.

A- B- C- D-

74. Зөв харгалзуулна уу.

A	Экспорт	1	Бараа үйлчилгээг гадаадад худалдах
B	Импорт	2	Бараа, үйлчилгээг гадаадаас худалдаж авах
C	Протекционист бодлого	3	Дотоодын үйлдвэрлэлийг хамгаалахын тулд гадаад худалдаанд хязгаарлалт хийх.
D	Демпинг	4	Үйлдвэрлэгчид гадаад орны шинэ зах зээлд нэвтрэхийн тулд өрсөлдөгчөөсөө доогуур үнээр бараагаа шахаж, дараа нь үнээ өсгөх зорилготой түр зуурын арга хэмжээ.

A- B- C- D-

75. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу.

A	Шаардлага	1	Төрийн бодлогын тодорхой илрэл болсон төрийн хууль тогтоомж, мэдээлэл, сурталчилгаа гэх мэт
B	Оролцооны дэмжлэг	2	Төрийн албан ёсны мэдээлэл, бэлгэдлийг хүндэтгэх
C	Бодит дэмжлэг	3	Тодорхой бодлого, шийдвэрийг дэмжиж буйгаа илэрхийлэх
D	Үйлдэл	4	Улс төрийн системийн дотроос эсвэл, түүнийг хүрээлэн байгаа экологи, эдийн засаг, соёл зэрэг янз бүрийн системүүдээс гарчбуй тулгалтууд

A- B- C- D-

76. Сонирхолын бүлгийн чиг үүргийг зөв харгалзуулаарай.

A	Агрегаци	1	Олон бүлгийн сонирхлыг илрүүлэн гаргах
B	Артикуляци	2	Явцуу олон шаардлагыг цэгцлэн, нэгтгэн боловсруулах
C	Интеграци	3	Бүлгийн гишүүдийн сонирхлыг нэг үзүүрт чиглүүлэх буюу нэгтгэх.
D	Улс төрийн нийгэмшилтийг хангах	4	Улс төрийн системийн оролтын чиг үүрэг

A- B- C- D-

77. Төрийн байгууллагуудын хүний эрхийг хамгаалах чиг үүргийг зөв харгалзуул

A	Улсын их хурал	1	Хүний эрхийн бие даасан, хараат бус байгууллага.
B	Засгийн газар	2	Хүний эрхийн зөрчлийг хянан шийдвэрлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх
C	Шүүх	3	Хууль тогтоох замаар хүний эрхийг хангах бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх
D	Хүний эрхийн үндэсний комисс	4	Хүний эрхийн хууль, тогтоомж, олон улсын гэрээний биелэлтийг хангах

A- B- C- D-

78. Олон улсын гэрээний хэлбэрүүдийг агуулгаар нь зөв тохируулна уу.

A	Тунхаглал	1	Хамгийн олон улс хүлээн зөвшөөрсөн баримт бичиг
B	Конвенц, пакт	2	Хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан баримт бичиг
C	Протокол	3	Хоёр болон түүнээс дээш улс хуульчлан дагаж мөрдөхөөр баталсан хүний эрхийн гэрээ
D	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	4	Хуульчлан дагаж мөрдөх албагүй, зөвлөмж уриалгын шинжтэй баримт бичиг

A- B- C- D-

79. Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллага, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудыг харгалзуулна уу. /5 оноо/

a	UNESCO	1	1957 онд Ромын гэрээгээр байгуулагдсан
b	ШХАБ	2	Шанхайн хамтын ажиллагааны байгууллага
c	Европын холбоо	3	НҮБ-ын “Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага”
d	UNICEF	4	Нэгдсэн үндэсний байгууллагын “Хүүхдийн сан”

A- B- C- D-

80. Олон улсын байгууллагын ангиллыг тохируулаарай.

a	Глобал түвшин	1	АСЕАН
b	Бүс нутгийн түвшин	2	Олон улсын гаалийн шүүх
c	Олон улс хамтран байгуулсан	3	Аль Кайда бүлэглэл
d	Хувь хүн байгуулсан	4	Евразийн эдийн засгийн холбоо

A- B- C- D-